



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/390

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1 дэх хэсэг, Магадлан итгэмжлэх зөвлөлийн 2024 оны 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн арванхоёрдугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Батбаяр)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (О.Энхболд)-т даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141241772

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
09 сарын 10 - ны өдрийн А/390
дугаар тушаалын хавсралт



**МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН НЭРС**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Улаанбаатар хот, "Би Ай Си" ХХК-ийн клиник	269/2024	1 жил	2024.09.20	2025.09.20
2.	Говь-Алтай аймаг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг	270/2024	2 жил	2024.09.25	2026.09.25
3.	Дорноговь аймаг, Даланжаргалан сумын эрүүл мэндийн төв	271/2024	2 жил	2024.11.01	2026.11.01
4.	Завхан аймаг, "Үе залгамжлагч-элит" ХХК-ийн сувилал	272/2024	3 жил	2024.12.31	2027.12.31
5.	Төв аймаг, Алтанбулаг сумын эрүүл мэндийн төв	273/2024	2 жил	2024.11.01	2026.11.01
6.	Төв аймаг, Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төв	274/2024	2 жил	2024.10.02	2026.10.02
7.	Төв аймаг, Баян-Өнжүүл сумын эрүүл мэндийн төв	275/2024	1 жил	2024.09.20	2025.09.20

---000---